



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

**Үнэт цаасны бүртгэлийн журмыг шинэчлэн
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, 47 дугаар зүйлийн 47.2.3, 47.2.7, 49 дүгээр зүйлийн 49.1.2, 49.1.4, 49.3, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.22 дахь заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Журмын шинэчилсэн найруулгыг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолоор баталсан журмыг Санхүүгийн зохицуулах хороо батламжилсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Энэхүү журмыг хүчин төгөлдөр дагаж мөрдсөн өдрөөс эхлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

152501101



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Гишүүнээр элсүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.5 дах заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Вантэйж капитал ҮЦК" ХХК-ийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үнэт цаасны арилжааны гишүүн брокероор элсүүлсүгэй.
2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гишүүнчлэлийн журмын дагуу "Вантэйж капитал ҮЦК" ХХК-тай Гишүүнчлэлийн гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг "Вантэйж капитал ҮЦК" ХХК (Б.Гүнбилгүүн)-д үүрэг болгосугай.
4. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, Гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010110



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015 оны 08 дугаар сарын 22

Дугаар 5

Улаанбаатар хот

“Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Бизнес төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан болон ТУЗ-ийн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайланг тус тус танилцуулах,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Энэхүү асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос 2015 оны 08 дугаар сарын 12-ны өдөр гарсан дүгнэлтийг хэрэгжүүлэхийг Дотоод аудитор (Г.Байгал, О.Ангирмаа)-т үүрэг болгов” гэжээ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525020014